

МОНГОЛ УЛСЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2024 оны 12 дугаар сарын 16

Улаанбаатар хот

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь
				Он	Түвшин		
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ							
9.1. Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.							
1	9.1.1.Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.						Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар: -Эко ногоон байгууламж (10, 12, 16, 17, 19 дүгээр хороо); -Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь (12 дугаар хороо); -Цэцэрлэгийн барилга (12 дугаар хороо), (комисс хүлээн авсан); -360 ортой 39 дүгээр цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих (комисс хүлээн авсан); -150 ортой цэцэрлэгийн барилга (16 дугаар хороо), (комисс хүлээн авсан); -200 ортой цэцэрлэгийн барилга (5 дугаар хороо), (комисс хүлээн авсан); -150 ортой цэцэрлэгийн барилга төлөвлөгдсөн боловч баригдаж эхлээгүй байна (23 дугаар хороо);

						-Дүүргийн 5-р сургуулийн өргөтгөлийн барилга ашиглалтад орсон (4 дүгээр хороо); -240 суудалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын ажил гүйцэтгэгч байгууллагаас шалтгаалан зогссон (19 дүгээр хороо); -640 суудалтай 175-р сургуулийн барилгын ажил хэвийн явагдаж байна (8 дугаар хороо); -100 ортой цэцэрлэгийн барилгын ажил хэвийн явагдаж байна (16 дугаар хороо); -960 суудалтай сургуулийн барилга, спорт заалны ажил газар чөлөөлөлтийн шатандаа байна (17 дугаар хороо); -150 ортой Тусгай хэрэгцээт хүүхдийн цэцэрлэгийн барилга газар чөлөөлөлтийн шатандаа байна; -240 ортой 108-р цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих ажлын гүйцэтгэгч шалгарч ажил эхэлсэн (6 дугаар хороо); -240 ортой 74-р цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих ажлын гүйцэтгэгч шалгарч, ажил хэвийн явагдаж байна (6 дугаар хороо); <i>Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр:</i> -Дүүргийн орон нутгийн төсвийн 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 16 дугаар хороонд “Жишиг өрхийн Эрүүл мэндийн төв”-ийн барилгыг ашиглалтад оруулсан. Мөн дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Ковид-19” халдварын хариу арга хэмжээний багуудын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор 128600000 төгрөгийн өртөг бүхий түргэн тусламжийн автомашиныг хүлээлгэн өгсөн. -Нийслэлийн Эрүүл мэндийн газрын 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны
--	--	--	--	--	--	---

						төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 170 сая өртөг бүхий түргэн тусламжийн машин хүлээлгэн өгсөн; -Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдах Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга, эмнэлгийн барилга барих 2.8 газрыг 6.5 тэрбум төгрөгөөр чөлөөлсөн; <i>Нийслэлийн төсвийн хөрөнгөөр:</i> -23 дугаар сургуулийн спорт заалыг буулгаж, усан бассейн бүхий спорт заал шинээр барих ажил хэвийн явагдаж байна (1 дүгээр хороо); -37 дугаар сургуулийн усан бассейн бүхий спорт заалыг шинээр барих ажлын гүйцэтгэгч шалгарсан; Хэрэгжилт: 100%
2	9.1.3. Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэхэд бүх шатны боловсролын байгууллагуудыг хамарсан төсөл хэрэгжүүлж, нийгэмд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааг төрийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж хэвшинэ.					“Нийслэл Улаанбаатар хотын гудамж талбай, түүхэн газруудтай танилцъя” сэдэвт аянд төрийн өмчийн 16 сургуулийн 107 бүлгийн 3592 хүүхэд, түүх нийгмийн ухааны заах аргын нэгдлийн багш нар болон багш, эцэг эхчүүд нийслэл хотын түүхэн газруудын талаар судлан мэдэх, тэдгээрийн онцлог, түүхийг хүүхэд багачууд, сургуулийн сурагчдад ойлгуулах, сурталчлан таниулах, өв соёлыг хадгалан дамжуулах зорилгоор дурсгалт газруудын тухай жуулчдад зориулсан танилцуулга хийх, ханын самбар, ханын сонин гаргах, хотын түүх дурсгалт газраар аялал зохиох, Улаанбаатар хотын гудамж талбай, түүхэн газруудтай холбоотой “АХА” тэмцээн, түүхэн кино, музей үзмэр үзэх мөн цахим шторк, контент, сурвалжилгыг хийсэн. Ерөнхий боловсролын 12 сургуулийн 145 бүлгийн 5295 сурагч Нийслэл хот үүсгэн байгуулагдсаны 385 жилийн ойг угтан “Улаанбаатар хотын түүхэн замнал” хичээлийг анги удирдсан багш болон мэргэжлийн багшаар дамжуулан Улаанбаатар хотын үүсэл хөгжил, түүхэн замналын талаар

						мэдээ мэдээлэл авч, харилцан ярилцаж, танин мэдэхүйн нээлттэй ярилцлага өрнүүлэх хичээл сургалтын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. Дүүргийн Замын цагдаагийн хэлтэстэй хамтран замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, төрийн өмчийн 16 сургуулийн 1-12 дугаар ангийн 360 бүлгийн 8627 сурагч хамрагдсан. Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчдад “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” аяны хүрээнд харилцаа, хандлага ёс, зүйн сургалт нөлөөллийн ажлыг дүүргийн 20 сургуульд 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл зохион байгуулж давхардсан тоогоор 7500 гаруй хүүхэд хамрагдсан. Зүрх сэтгэлийн боловсрол олгох EQ хөтөлбөрийг төрийн өмчийн 8 цэцэрлэгийн 48 багш, 850 хүүхэд, 1190 эцэг эхэд хэрэгжүүлсэн. Байгууллагын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр “Соёлыг түгээе” видео контентыг 38 цэцэрлэгт хүргүүлэн 1400 багш, ажилтанд хүргэн ажилласан. Хэрэгжилт: 100%
9.2. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.						
3	9.2.4. Олон Улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.					Дүүргийн 7, 20 дугаар хороонд Самбалхүндэвийн гудамжны авто зам дагуу 0.24 км дугуйн болон 1500 м2 явган замын ажлыг “Чингисийн отог” ХХК хийж гүйцэтгэсэн. 87у/м блокон хашааг замын трасын дагуу чөлөөлж, 150у/м байгалийн чулуун зам барихаар замын трасыг чөлөөлөх ажлыг хийж гүйцэтгэж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Интел хайтек” ХХК нь Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо, “Теди” төвийн үүдэнд 100м2 дугуйн зам, 356м2 явган замын ажлыг

							хийж гүйцэтгэн комисс ажилласан. Мөн 2024 онд дүүргийн 15 дугаар хороо, жаргалантын 11 дүгээр гудамжнаас Ерөнхий боловсролын 72 дугаар сургууль хүртэл 240 у/м, 4 дүгээр хороо, 9 дүгээр байрны урд талын явган зам 110 у/м, 20 дугаар хороо, хувьсгалчдын Г-ийн 12 дугаар гудамжнаас зурагтын зам хүрэх явган хүний гүүр хүртэлх явган зам 150 у/м, 20 дугаар хороо, 149 дүгээр сургуулийн урд талын хашаа дагасан явган зам 131у/м, 7 дугаар хороо, “Даргиат булаг” дэлгүүрийн дэргэдэх шат болон Г-540 тоот явган зам засвар 10 у/м явган замын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Хэрэгжилт: 70%
Үнэлгээний дундаж							90.0%